

**САЙД ЯРЬЖ БАЙНА**



Гэрэл зургийг Г. АРГУУЖИН

**УЛС ТӨР**

МАХН-ЫН ГИШҮҮН ТЭРБИШЦАГВЫГ  
“УРВАГЧ” ГЭЖ ХАШГИРСААР НАС  
БАРЖЭЭ

II нүүрт

**ОНИЦЛОХ ХУУДАС**

СОДОН “СОЛИОТОЙ”  
СУРТАЛЧИЛГААНУУД

V нүүрт

**ҮЗЭЛ БОДОЛ**

## АРД ТҮМНИЙГ ДААПААЛЖ ХАНААГҮЙ ЮУ, АН-ЫНХААН

–Хувьцаагаа зарсан мөнгө архины үйлдвэрийн ашгийг нэмэгдүүлж, наадмаар наргих мөнгө болоод дуусна–

**Б.ТОГТОХ**

Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар өчигдөр энэ оны эхний таван сарын байдлын статистик тоон үзүүлэлтийг танилцуулла. Улсын хэмжээнд гэмт хэргийн гаралт буурсан, инфляци өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан зэрэг ганц нэг гялтайх мэдээ дуудаж байгаа ч сайнаасаа саар мэдээлэл илүү олныг дуулгав. Банкны системийн хэмжээнд чанаргүй зээлийн хэмжээ 17 хувьд хүрсэн нь аюулын харанга.

Тэр тусмаа банкууд орон сууцны зээл олгохоо болих, зээлээ хумих бодлого баримтлах зэрэг асар олон сөрөг үр дагавар авчрах эрсдэлтэй бид тулгарчээ. Үнэнийг нуух аргагүй болчихож. Мөн улсын төсвийн нийт тэнцэл 877 тэрбумын алдагдалтай гарсан муухай мэдээг тэд дуулгалаа. Нэгхэн сарын өмнө 670 тэрбум байсан алдагдал 30 хоногийн хугацаанд 200 тэрбумаар нэмэгдсэн нь өнөөдөр эрх барьж буй хүмүүсийн санаагаа чилээх асуудал мөн байлтай.

Үргэлжлэл нь III нүүрт

Дугаарын **60** мөр

Орон сууцанд амьдарч байгаагаа ойлгодог ч болоосой

**Б.ӨНӨРТӨГТОХ**

Тал нутгаар нүүдэллэн амьдардаг байсан монгол түмэн суурин амьдарлыг сонгосноос хойш тийм ч олон зууныг үдээгүй байна. Жилийн дөрвөн улиралд малаа дагаж нүүдэллэж ирсэн бидний хувьд суурин иргэншлээр амьдарч, дөрвөн ханан дунд хашигдаж амьдарна гэдэг эхэндээ амаргүй байсан нь мэдээж. Гэвч суурин соёлыг сонгосноос хойшхи энэ хугацаанд бүхэл бүтэн нэг үе солигдчихоод байгаа билээ. Тэр тусмаа ардчилсан нийгмийг сонгосон шинэ үеийн хийж бүтээх хөдөлмөрлөх цаг ирчихсэн. Харамсалтай нь манайхны ухамсар өнөөх л хээр талд адуугаа харнулж, хонио эргүүлж явдаг задгай сэтгэхүйнээс гараагүй байгаа юм. Гудамжинд хогоо хаядаг, нус цэрээ машинныхаа цонхоор төвөггүйхэн нулимчихдаг, нийтийн эзэмшлийн зам талбайг хайрлаж хамгаалах ухамсар бүрэн төлөвшиж чадаагүй.

Үргэлжлэл нь III нүүрт

### М.ЗОРИГТ:

АЗИ, ЕВРОП ТИВИЙГ ХОЛБОСОН “ЭДИЙН  
ЗАСГИЙН КОРИДОР” БАЙГУУЛАХ БОЛСНОО  
ДЭЛХИЙ ДАХИНД ТУНХАГЛААД БАЙНА

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр +22  
Шөнө +9

**ӨӨР ӨНЦӨГ**

### ҮҮЛИЙГ ДАХИН ХОТЫН ДАРГААР СОНГОСОН НЬ УЧИРТАЙ



Э.ТУУЛ

УИХ-ын гишүүн болон аймаг, нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчдийг сонгох сонгууль энэ сарын 29-ний өдөр болно. Тэгвэл өнгөрсөн бямба гарагт буюу энэ сарын 11-ний өдөр УИХ-ын гишүүн болон аймаг, нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчдийг сонгох сонгуулийн сурталчилгааны албан ёсны нээлт болсон юм. Нийслэлийн Ардчилсан нам Монгол бөхийн өргөөнөө сонгуулийн сурталчилгааны нээлтийн ажиллагаагаа зохион байгуулахын зэрэгцээ нийслэлийн ИТХ-д нэр дэвшигчид энэ өдөр анхдугаар хуралдаанаа хийж, 2016-2020 онд нийслэлийн Засаг дарга буюу Улаанбаатар хотын Захирагчийг томиллоо. Үүнийг сайшаах нэгэн байхад буруушаах хүн ч бас байгаа аж. Яг үнэндээ ардчилсан үзлийг дэмжигч, дэлгэрүүлэгч, хайрлан хамгаалагч орнуудын дээд жишиг ийм байдаг. Тодруулбал, ардчилал хөгжсөн олон оронд сонгууль болохоос өмнө хэнийг ямар албан тушаалд томилгоо урьдчилан зарладаг. Ингэж урьдчилж зарлах нь ардчилсан сонгуулийн нэгэн

соёл. Манайх шиг сонгуулийн дүн гарсны дараа ханцуй дотроо наймаалцаж, албан тушаалын бялуу хуваадаггүй байх нь. Тиймээс ч Монгол Улсад сонгуулийн соёл тогтоох анхны алхмыг нийслэлийн Ардчилсан нам хийлгээ хэмээн дүгнэх гээд байгаа юм.

Хийсэн ажил нь нүдэнд харагдаж, гарт баригдана

Өнгөрсөн 2012 онд нийслэлчүүд Э.Бат-Үүл ба түүний нөхдийг багаар нь дэмжиж, нийслэлийг хөгжүүлэх даалгаврыг өгсөн. Тэгвэл Э.Бат-Үүл ба түүний нөхд нийслэлчүүдийнхээ даалгаврыг хүлээн авч, ажилдаа ханцуй шамлан орсноос хойш аль хэдийнэ дөрвөн жил өнгөрчээ. Энэ хугацаанд нийслэлд олон өөрчлөлт гарч, их шинэчлэл хийгджээ. Тэдний хийсэн бүхэн өнөөх “шилэн данс” гэдэг шиг олны нүдний өмнө илхэн, гарт баригдаж байгаагаараа бусдаас ялгарна. Тухайлбал, түгжрэлтэй уулзваруудын түгжээг арилгаж, шинэ цэцэрлэг, сургуулиуд үүд хаалгаа нээж, нерв бардаг автомашинаасаа нэг өдөр салдаг болсон, дугуйн замаар дураараа давхиж, ухаалаг нийтийн тээврээр ухамсартай үйлчлүүлж, төрийн үйлчилгээг авлига, арын хаалгагүй авдаг болсон, бохиртойгоо зууралдсан борго амьдралдаа ч баяртай гэж хэлж чадсан он жилүүд байсан гэхэд болно.

Үргэлжлэл нь II нүүрт

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ **15400**

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

ХААН Банк			Хугалгаа хөгжлийн банк		
	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	1966.00	1980.00	ФУНТ	2744.00	2826.00
ЕВРО	2189.00	2242.00	РУБЛЬ	28.70	32.70
ИЕН	18.30	18.76	ЮАНЬ	297.50	300.80







# ОНЦЛОХ ХУУДАС

## Сенсаацийн эргэн тойронг

# СОДОН “СОЛИОТОЙ” СУРТАЛЧИЛГААНУУД



## Сэтгүүлчийн өнцөг

# СОНГУУЛИЙН МОДЕРНИЗМ

Н.ПУНЦАГБОЛД

Саяхан л ганц бие байсан найз минь гэр бүлийн гишүүнтэй болж гэнэ ээ. Эхнэр авсан юм байх гэж бодсон чинь үгүй бололтой юм. Сонгуулийн үеэр зарим нэг нэр дэвшигчид нь мань хүний гэр бүлийн гишүүн болох бололтой юмдаг уу даа. Орой очиход нь хоол ундыг нь хийгээд, гэр орныг нь цэвэрлээд өгөх юм байх. Цаашлаад юу эсийг хийх билээ. Тийм учраас нэмэгдээд ирэхээр жаахан хэцүү байгаа бололтой. Зарим нэг нэр дэвшигчид айд “Би ирлээ” гэж орчихоод, нөхөр нь ирэх гээд байхад явахгүй жаахан зовоогоод байгаа бололтой.

Хөөрхийс цахим ертөнцөөр л нэг бичээд, тусламж ч гуйгаад байгаа юм уу, бүү мэд. Нэгэн үе нэр дэвшигчид маань “Танд тэдэн төгрөг өгнө. Ингэж ч амьдралыг чинь өөд нь татна” гэж амалдаг байсан бол одоо арай орчин үежиж байгаа юм уу даа. Нэг ёсондоо модернист болж байгаа ч байж болох. Угаасаа сүүлийн жилүүдэд реализмаас татгалзаад, бүх зүйлийг шинэчилж эхэлсэн хойно. Тиймдээ ч сонгуулийн үеэр сонгогчдынхоо гэрт очиж, гэр бүлийнх нь гишүүн болсон ч яахав гэсэн чинь сэтгэлийн хандлагыг зарим нэг хүн зарчмаа болгож байх шиг. Тэр дундуур бас огт ойлгомжгүй сэтгэлгээтэй нөхдүүд ч бас байгаа юм. “Өмнөговно өөрсдөө л хөгжүүлцгээ, би бол зүтээр л та нарыг УИХ-д төлөөлнө” гэж ойлгож болохоор салааутга бүхий тун ч өвөрмөц уриаг дэвшүүлсэн хүн байна. Эсвэл “Гоё зорилго,

...“Голоос хайртай амраг минь, шөнөдөө гэрэлтэм царайлаг даа” гэж нэг дуу бий дээ. Тэгвэл энэ дууг манай нэг улстөрч болох гэж байгаа эмэгтэйд зориулж зохиосон юм байна лээ. Аргагүй гэрэлтдэг учраас “Гэр орныг тань гэрэл гэгээтэй болгоно” хэмээн уриалсан байна...

гоё сонголт” гэх хэд хэдэн салаа утгыг илэрхийлсэн жинхэнэ модернист уриаг дэвшүүлсэн нэр дэвшигч ч байгаа юм. “Гоё” тарагны реклам ч юм уу. Яруу найрагч бол манай Б.Галсансүх ахын шүлэгтэй төстэй юм уу даа. Гоё зорилго нь ч өөрөө юм шиг. Гоё сонголт нь ч бас өөрөө. Ерөнхийдөө жаахан гоёхон дуу хүүхэн сонгогчид зориулж чинь биеллээ ч гэж байгаа юм бил үү, хэн мэдлээ. Утга нь битүү, филсофи ханхалсан уриа үг болохоор нийтэд ижил ойлгогдох албагүй л дээ. Хүн бүр өөрийнхөөрөө ойлгож болно. Нэр дэвшигчид дунд уриа нь биш өөрөө ийм ханхлуулсан нөхдүүд цөөнгүй байна. Өнгөрсөн хугацаанд ажилласан манай улстөрчид үзэгний үзүүрээр, киноор бүх зүйлийг шийддэг байсан бол цаашид хогийн шүүр хэрэглэдэг болох бололтой юм. Томхон байх тусмаа сайн гэнэ ээ. Мань мэтийн сэтгэх нь ээ,

ямар ч байсан төрийн ордон хоггүй л байх нь. Хүүе ээ, мартсанаас мал мэнд үү гэдэг шиг “Эгэл баатар” гэдэг цол гарчихаж ээ. Зарим нэг хүн энэ цолоор шагнуулаад, баатруудын эгнээг тэлж байгаа юм байна. Баатар цолтой хүмүүс өндөр албан тушаалд их сууж байгаа өнөө цагт барьцахгүй бол бас болохгүй л дээ. За энэ юу ч биш. “Голоос хайртай амраг минь, шөнөдөө гэрэлтэм царайлаг даа” гэж нэг дуу бий дээ. Тэгвэл энэ дууг манай нэг улстөрч болох гэж байгаа эмэгтэйд зориулж зохиосон юм байна лээ. Аргагүй гэрэлтдэг учраас “Гэр орныг тань гэрэл гэгээтэй болгоно” хэмээн уриалсан байна. Манай Улаанбаатар хотын захын гэр хороололд тог цахилгаангүй айлууд цөөнгүй байдаг юм билээ. Тэд нэг нэг өдөр гэртээ аваачвал ядаж л ганц хоног ч болов гэрэлтэй байх нь. Сонгууль болж байхад тэр зэргийн юмыг

хийгээд өгчих байлгүй дээ. Бас нэгэн өвөрмөц хүн хэрвээ намайг сонговол би юм ярихгүй, сонсоод л байна гэж амалсан байна. Амлах ч юу байхав хөөрхий, үнэнээ хэлсэн нь тэр байлгүй дээ. Дөрвөн жил сонсч, тууштай суралцах нь түүний гол зорилго байх. Түүнийгээ ч зоригтой хэлж. Ийм зориг олон хүнээс гарахгүй шүү дээ. Жинхэнэ сонгодог. Сонгуулийн сурталчилгаа нэг иймэрхүү л гүн ухаанлаг, нэм ханхлуулсан эхэлж байна. Иргэдэд нэг л зүйлийг захираар санагдлаа. Энэ бол хошин шог биш, бодит зүйл. Зүгээр л өмнөх жилүүдийнхээс арай өөр урсгал чиглэлээр ажиллаж байгаа юм. Угаасаа гүн ухааныг нэг хэв загвараар ойлгох ямар ч боломжгүй. Тийм болохоор өөр өөрийнхөөрөө ойлгоод явчихна биз. Харин тэр гэр бүлийн гишүүн болох гээд байгаа нөхдүүдийг хэд хоног хэрэглэхгүй юу яадаг юм.

## ДЭЛХИЙ

## ДОНАЛД ТРАМП VS ХИЛЛАРИ КЛИНТОН

Б.ДАВАА

АНУ-ын төрийн тэргүүнийг сонгох сонгууль ирэх арваннэгдүгээр сард тохионо. Энэ сонгуульд Ардчилсан намаас Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон нэр дэвшч буй бол Бүгд найрамдах намаас Доналд Трамп өрсөлдөхөөр болсон. Хилари эдүгээ 68 настай бол Доналд 69 настай бөгөөд тэд нэгэн үеийн лидерүүд. Гэсэн ч, хоёр эрхэмд нийтлэг чанар бараг үгүй аж. Намтар, хүйс, улстөрчийн туршлага гээд бараг хоорондоо тэс өөр хүмүүсээс америкчууд сонголтоо хийж юм. Сонгууль болоход таван сарын хугацаа үлдсэн. Тэгвэл уг сонгуульд нэр дэвшигчдийн давуу талыг “Франц пресс” агентлаг харьцуулан гаргасныг уншигчиддаа орчуулан хүргэе.



## Улс төрийн туршлагагүй бизнесмэн

Түүнийг дэмжигчдийн ихэнх нь Трампыг мөнгөө өсгөх олон авьяастай бизнесмэн гэж тодорхойлдог бөгөөд ажилгүйдлийг бууруулж, эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулж чадна хэмээн үнэлдэг. Трампын нийт хөрөнгө 10 тэрбум ам.доллар. Гэхдээ тэрбээр өөрөө үүний хагаст ч хүрэхгүй хөрөнгөтэй гэдгээ онцолдог байна. Ардчилсан намын хувьд түүнийг улс төрийн туршлагагүй гэдгээр рейтингийг нь унагах сонирхолтой байдаг. Түүнчлэн, казиногийн бизнес хийх гээд бүтэлгүйтсэн болоод Трамп их сургуулийг байгуулсан гэх зэргээр шүүмжлэхийг оролддог байна.

## Интертайнер

Доналд Трамп өөрийнхөө сонгуулийн кампанит ажлынхаа үеэр зорьсон зорилгоосоо огтхон ч ухрахгүй хэмээн онцлон тэмдэглэж байв. Түүний сонгуулийн сурталчилгааны үеэр мөргөлдөөн, эсэргүүцлийн жагсаал ч болж байсан. Трамп хэлсэн үг, элдэв мэдэгдлээсээ болоод хэл аманд өртөх нь элбэг. Өнөөдрийг хүртэл түүний амнаас гарсан үгс зарим талаар дэмжигчдийнх нь тоог нэмэгдүүлсэн ч, нөгөө талаар эсэргүүцэгчдийнх нь бухимдлыг тэрүүлэх нь олонтай. Гэхдээ 1980-аад оноос хойш Нью-Йоркийн томоохон сонины нүүрийг тасралтгүй чимж ирсэн Доналд Трамп хэвлэл мэдээллийг хэрхэн өөрийн талд ашиглахаа мэддэг авьяастай нэгэн ажээ. Бусад нэр дэвшигчдээсээ илүү телевизийн нэвтрүүлгүүдэд оролцож байснаас нь ийн дүгнэлт хийж болно. Бодсон санаснаа шулуухан хэлчихдэг нимжээрээ олны анхаарлыг татаж, улмаар Хиллари Клинтонь өмнө маш том хана босгож чадсан эрхэм юм.

## Түүхэнд нэрээ үлдээсэн эмэгтэй

Америкийн их сургуулийн судлаач Женнифер Лаулесс гэгч эмэгтэй “Хиллари Клинтон хэрвээ энэ сонгуульд явбал цагаан арьст Ерөнхийлөгчөөс гаднах ерөнхийлөгчийн хоёрдугаар үеийг үргэлжлүүлнэ” гэж тодорхойлжээ. Хиллари ирэх сонгуульд ялсан ч, ялаагүй ч түүний нэр түүхэнд бичигдэж үлдэх нь тодорхой. Учир нь тэрбээр Ардчилсан намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшсэн анхны эмэгтэй билээ. Хэрэв сонгуульд ялбал, мөн л АНУ-ын анхны эмэгтэй Ерөнхийлөгч болох юм. АНУ-ын түүхэн дэх 227 жилийн хугацаанд Ерөнхийлөгчийн сонгуульд нэг ч удаа эмэгтэй хүн нэр дэвшч байгаагүй ажээ. 1789 онд шинээр тусгаар тогтносон АНУ-ын Ерөнхийлөгчөөр Жорж Вашингтон сонгогдож байсан. Түүнээс хойш нийтдээ 44 эр АНУ-ын сонгуульд ялалт байгуулж, тус улсыг удирдаж байснаас 43 нь цагаан арьстан байсан гэдэг. АНУ-ын хамгийн анхны өнгөт арьст Ерөнхийлөгч бол Барак Обама билээ. Харин 45 дахь Ерөнхийлөгчийг сонгох сонгуульд ялбал цагаан арьстан эрэгтэйчүүд ялдаг тогтсон хэвшлийг өөрчилж буй гэдгээрээ хоёрдугаар эриний удирдагч болох ажээ.

## Сэв үгүй намтар

Хиллари Родхам Билл Клинтонтой гэрлэж, нөхрийнхөө овгоор овоглохоосоо өмнө ч нэр алдартай байсан гэдэг. Залуухан өмгөөлөгч бүсгүй эмэгтэйчүүд, хүүхдүүдийн төлөө тэмцэж, байр сууриндаа бат зогсоор иржээ. Гэсэн ч, нөхөр болох АНУ-ын Ерөнхийлөгч асан Билл Клинтонь улс төрийн хүрээнд дэмжихийг тулд өмгөөлөгчийн ажлаасаа холдож, нөхрийнхөө хамтаар Арканас мужийн захирагчийн ордон, дараа нь Цагаан ордон рүү нүүсэн байна. Энэ хугацаанд өөрөө ч улс төрийн ертөнцөд хөл тавьсан байлаа. Нью-Йорк мужаас хоёр ч удаа сенатад сонгогдож, Барак Обамагийн дор Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан удаатай.

## ТЭНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 06 дугаар сарын 03-ны өдөр  
**Тендер шалгаруулалтын нэр:** ХОР СААРМАГЖУУЛАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ХУДАЛДАН АВАХ  
**Тендер шалгаруулалтын дугаар:** ИХ-2016/09-018

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК нь эрх бүхий тендер оролцогчдоос нийлүүлэх Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50 000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Голомт банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 400 102 2146 тоот дансанд төлсөн байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

## Үүнд:

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 3 жилийн /2013,2014,2015 он/ -ийн аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 100 сая төгрөгөөс багагүй байна.

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жил /2013,2014,2015 он/

**Тендерийн хамт:** 1-р багц - 3,325,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

2-р багц - 2,612,500 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

3-р багц - 2,137,500 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

4-р багц - 4,200,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

5-р багц - 4,675,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

6-р багц - 3,825,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

7-р багц - 2,530,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

8-р багц - 2,530,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

9-р багц - 900,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

## Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

## Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцно.

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

ОРХОН АЙМАГ, БАЯН-ӨНДӨР СУМ, НАЙРАМДАЛ ТАЛБАЙ  
ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРГААНЫ БАЙР, 347 ТООТ ӨРӨӨ  
УТАС: 01-352-73371 ФАКС: 01-352-73686  
ВЭБ САЙТ: WWW.ERDENETMC.MN  
E-MAIL: MYAGMARKHAND@ERDENETMC.MN

## “Евро-2016” тэмцээний үеэр архи худалдахыг хориглолоо

Францын Засгийн газраас “Евро-2016” хөлбөмбөгийн ЕАШТ-ийг зохион байгуулж байгаа хотуудын цэнгэлдэх хүрээлэн болон хөгжөөн дэмжигчдийн асруудын ойролцоо согууруулах ундаа худалдан борлуулахыг хориглох шийдвэрийг гаргажээ. Марсель хотод хөгжөөн дэмжигчдийн хооронд зодоон болсонтой холбогдуулан дээрх шийдвэрийг гаргасан байна. Хэргийг эргэн сануулбал, өнгөрсөн бямба гарагт Орос, Английн шигшээ багууд хэсгийн эхний тоглолтоо Марселийн

“Stade Velodrome” цэнгэлдэх хүрээлэнд хийж, 1:1 харьцаагаар тэнцсэн. Гэвч тоглолтын дундуур Оросын хөгжөөн дэмжигчид гэрэл цацруулагч шидэж, улмаар тоглолт дууссангуут Английн хөгжөөн дэмжигчдийн сууж байсан хэсэг рүү дайрнаар зодоон эхэлжээ. Энэ мэтээр Оросын хөгжөөн дэмжигчид цэнгэлдэх хүрээлэн дотор үймээн самуун дэгдээсэн учир УЕФА-гийн зүгээс Оросын Хөлбөмбөгийн холбооны эсрэг сахилгын арга хэмжээ авахаа мэдэгдээд байгаа юм.

## Цагт 17 хүн зам тээврийн ослоор нас барж байна



Энэтхэгийн Зам тээврийн сайд Нитин Гадкари тус улсад нэг цагт дунджаар 17 хүн зам тээврийн ослоор нас бардаг тухай Засгийн газрын хуралдааны үеэр мэдээлж, яаралтай замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг шинэчилж, дэд бүтцийг сэргээн засварлаж, замын хөдөлгөөний дүрмийг чангатгахаа амласан байна. Түүний мэдэгдэлд дурьдагдсанаар 2015 онд

гэхэд Энэтхэгт 501423 удаагийн зам тээврийн осол гарч, 146133 хүн нас баржээ. Энэ тоо нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс таван хувиар өссөн үзүүлэлт юм. Харин гэмтэж бэртсэн хүмүүсийн тоо 500 мянгыг давсан байна. Түүнчлэн, зам тээврийн 10 осол тутмын найман нь дүрэм зөрчсөнөөс үүдэлтэй байдаг бөгөөд үүний 62 хувь нь хурд хэтрүүлсэнгүй холбоотой байдаг аж. Зам тээврийн сайд Нитин

Гадкари “Энэтхэгт терроризм, байгалийн гамшгаас илүү зам тээврийн ослоор нас барсан хүний тоо их байна. Тиймээс энэ асуудалд анхаарлаа хандуулах шаардлага нэгэнт бий болжээ” хэмээн сэтгүүлчдэд ярьсан байна. Мөн цаашдаа замын түгжрэлийг бууруулахын тулд хурдны зам шинээр барьж, авто замын засвар шинэчлэлийг ажлыг хийхээс гадна осол гаргасан жолоочид долоогоос дээш жилийн хорих ял ногдуулах заалтыг зам тээврийн аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад оруулж ирэхээр болжээ. Дашрамд дурьдахад, тус улсад хуурамч жолооны үнэмлэхээр хөдөлгөөнд оролцох жолооч нар нэлээд их байдаг гэнэ. Тодруулбал, Энэтхэгт ашиглагдаж буй жолооны үнэмлэхийн ойролцоогоор 30 хувь нь хуурамч байдаг байна.



## ЗАВСАРЛАГА

ОДДЫН ЦАГ

СУН ХЕ ГЮ: БИ ИРЭЭДҮЙН ТАЛААР  
ТОМ ЗҮЙЛ ТӨЛӨВЛӨДӨГГҮЙ

Орчуулсан Б.ДАВААХҮҮ

"Asian Box" киноны сувагаар Солонгосын олон ангит "Нарны үр сад" кино гарч, манай үзэгчдийг байлдан дагуулж байгаа билээ. "Зочид буудлын эзэн", "Амьдралын ээдрээ", "Миний байшин" зэрэг үзэгчдийн сэтгэлд хоногшиж үлдсэн олон ангит киноны дүрээрээ танигдсан Солонгосын царайлаг, үзэсгэлэнт жүжигчдийн нэг Сун Хе Гю уг киноны гол дүрийг бүтээж байгаа юм. Тэгвэл энэ удаа "Оддын цаг" буландаа жүжигчин бүсгүйн [www.koreatimes.co.kr](http://www.koreatimes.co.kr) сайтнаа өгсөн ярилцлагыг орчуулан хүргэж байна.

"Нарны үр сад" киноны романтик хэсгийн сэтгэл хөдлөлийг жүжигчин Сон Жун Ки та хоёр маш чадварлаг гаргасан байна билээ. Ийм мундаг тоглосон нууц нь чухам юундаа байна вэ?

-Кино дэлгэцнээ гарснаас хойш Сон маш олон шүтэн бишрэгчидтэй болсон байна лээ. Кино зохиолыг анх унших үедээ гол дүрийн эрэгтэй жүжигчин хэрхэн удирдаж тоглохоос шалтгаалж, кино амжилтад хүрэх юм байна гэж бодсон. Харин хамтрагч маань дүрээ сайн гаргасан учраас миний сэтгэлийг хөдөлгөж чадсан байх. Тиймээс л энэ хэсэг үзэгчдийн сэтгэлд хүрч чадсан юм болов уу.

"Мишүбиши моторс" компанийн нүүр царай болох саналаас тагталзсан гэж сонссон юм байна. Хэрэв дургүйцэхгүй бол шалтгааныг нь тодруулж болох уу?

-Тэр явдлын талаарх мэдээлэл маш хурдацтай тархаж байгааг хараад үнэндээ гайхсан. Өөр солонгос жүжигчин байсан ч, ийм шийдвэр гаргах байсан байх. Надтай холбоотой бүхий л үйл ажиллагаа, гэрээ хэлцлийг Сео Кён Дук хариуцдаг юм. Гадаадын олон алдартай музейд солонгос хэл дээрх товхимол байгааг би нэг ч удаа олж харж байгаагүй. Тиймээс менежертэйгээ ярилцаад Солонгосын соёл руу чиглэсэн үйл ажиллагаанд түлхүү оролцохоор шийдсэн. Түүхийн талаарх баримтуудыг сайн мэдэхгүй учраас маш

олон зүйлсийг судлах хэрэгтэй болж байгаа. Би өөрийнхөө зөв гэж бодсон зүйлээ л хийх болно. Бусад хүмүүс юу гэж хэлэх нь хамаагүй.

-Сүүлийн хоёр ангийг дутуудсан гэж зарим хүмүүс дүгнэж байгаа. Та үүнтэй санал нийлэх үү?

-Киноны сүүлийн ангийн зураг авалтыг урьдчилж авсан байсан. Гэхдээ олон нийтэд цацах үед зарим хэсэг дутуудсан нь үнэн. Кино зохиолыг бүхэлд нь уншиж, нэг хэсэгт нь тоглосон хүний хувьд ингэж хэлж байгаа хэрэг. Зарим үзэгчид сөрөг сэтгэгдэлтэй үлдсэн байх. Хувь хүнийхээ хувьд би төгсгөлд дуртай л даа. Гэхдээ олон ангит кино болохоор зүгээр гэж бодож байна.

-Өөрийн бүтээсэн дүр болох доктор Кан Мо Ены талаар юу гэж бодож байна вэ. Зохиолч Ким Ен Суккийн бичсэн ховорхон дүрүүдийн нэг шүү дээ?

-Кан эмчийн дүр өөрийнх нь бичсэн зохиолууд дундаа хамгийн анхны шулуун шударга, өөртөө итгэлтэй бүсгүйн дүр гэж зохиолч Ким хэлж байж билээ. Үнэнийг хэлэхэд зохиолчтой уулзаж, ярилцахаасаа өмнө нь би дүрийнхээ талаар сайн ойлголтгүй явсан. Харин түүнтэй уулзах үедээ дүрийнхээ гэрэл гэгээтэй сайн талыг нь илүүтэй олж харсан юм. Тэгээд л зохиолоо дахин уншиж, Кан эмчийн дүрийг бүтээсэн дээ.

-Та энэ удаагийн олон ангит киноноос юу сурч үлдсэн бэ?

-Би 20 гаруй насандаа жүжиглэнэ гэдгийг их л амархан зүйл гэж бодож, төсөөлж ирсэн. Гэхдээ энэ киноны бүх л хэсэг тийм амар байгаагүй. Зураг авалт эхлэх тэр үеэс ажлаа сайн хийхэд л анхаарч байлаа.

-Хамтран тоглосон жүжигчин Сон Жон Киг хүнийх нь хувьд юу гэж боддог вэ. Манай зарим уншигчдад сонин байж магадгүй?

-Сон Жон Ки аливаа зүйлд чин сэтгэлээсээ ханддаг, эелдэг зантай гэдгийг нь мэднэ. Газар хөдлөлт гэх мэт хүнд зураг авалтад ч тэр ийм л байдлаар хандаж ирсэн. Бүтэн зургаан сарын турш хамт ажиллахад түүний зан араншин өөрчлөгдөхийг нэг ч удаа хараагүй. Сон насаар надаас хэд дүү. Гэхдээ надад түүнээс сурах зүйл маш их байлаа. Кинонд дүрээ төгс бүтээсэн гэдэгтэй маргахгүй байх. Хүнийхээ хувьд ч гайхалтай залуу.

-Таны тоглолт ч гэсэн гайхалтай байсан. Ер нь таны хувьд үзэгчиддээ ямар байдлаар дурсагдахыг хүсдэг вэ?

-Кино, драмын аль нь ч бай, миний тоглосон дүр үзэгчдийн сэтгэлд маш гүн гүнзгий хүрэхэд л миний сэтгэл ханах болно. Би ирээдүйн талаар том зүйл төлөвлөдөггүй. Яг одоогийн байдлаар миний хамгийн сайн чадах зүйл энэ байна.

-Таны дараагийн бүтээхийг хүсч буй дүрийн тухайд?

-Эрэгтэй жүжигчидтэй харьцуулахад эмэгтэй жүжигчдийн бүтээж чадахгүй дүр гэж байдаг. Ингэж хэллээ гээд эрэгтэй жүжигчид эмэгтэйчүүдээ илүү чадвартай гэж байгаа юм биш. Би зүгээр л зохиолчдын бичсэн олон олон эмэгтэйн дүрийг драм болон дэлгэцийн бүтээлд бүтээж, жүжигчнийхээ ур чадварыг өөр талаас нь харуулахыг л хүсч байна.

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр +24  
Шөнө +9Нөгөөдөр  
Өдөр +23  
Шөнө +9

Аргын тооллын:

2016 оны 6-р сарын 13,  
Мягмар гараг

Билгийн тооллын:

Шинийн 9. Таван шар  
лэнгэтэй Улаан баг өдөр.

Наран ургах/шингэх:

06:02 - 21:48

Үс засуулбал:

Өвчин өчүүхэн ирнэ



Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, талхи татах, сэтгэл муутантай нохойлох зэргийг үзэрлэх хэрэгтэй ба сүл дуганыг сэргээх, альуулах, өглөгийн түлээг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Гөлөг тэжээх, золиг гаргах, болбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохойболгой. Хол газар яваар одоосод баруун урагш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиролжгүй.

ТЭНГИС  
КИНО ТЕАТР

МАНАЙ ДЭЛГЭЦНЭЭ...

Төгсгөлөөс илүү  
Тэнгис 776...

tel: 313105

[www.facebook.com/tengismovie](http://www.facebook.com/tengismovie)  
<https://ticket.tengis.mn><https://twitter.com/tengismovie>  
[www.tengis.mn](http://www.tengis.mn)1900-1617 -руу залгаад тасалбар захиалга,  
үнэггүй хүргэлттэй боллоо